



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 07 сарын 17 өдөр

Дугаар А/57

Улаанбаатар хот

### ЖУУЛЧНЫ МЭДЭЭЛЛИЙН ТӨВҮҮД АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/524 захирамж, газрын дүрмийн 2.5.3, 3.1.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлд аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилтын хүрээнд дотоод, Үндэсний их баяр наадам болон Хүрээ цам-Даншиг наадмын үеэр гадаадын иргэд, жуулчдад баяр наадмын талаар мэдээлэл өгөх, хэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилготойгоор Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дэргэдэх явуулын "Жуулчны мэдээллийн төв"-ийг Хүй Долоон худаг болон Төв цэнгэлдэх хүрээлэнд ажиллуулахыг Мэдээлэл, сурталчилгааны төвийн менежер /С.Баяржаргал/-т даалгасугай.

2. Явуулын мэдээллийн төв байгуулахад шаардагдах зардлыг хавсралт ёсоор баталсугай.

3. Явуулын жуулчны мэдээллийн төв ажиллуулахад шаардагдах зардал болох 3,050,000 /гурван сая тавин мянга/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д даалгасугай.

ДАРГА *D. Balin* Д.БАТСҮХ



1150590221

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2017 оны 07 сарын 07  
өдрийн А/БТ дугаар тушаалын хавсралт



ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ҮЕЭР ЯВУУЛЫН  
МЭДЭЭЛЛИЙН ТӨВҮҮД АЖИЛЛУУЛАХ ТӨСВИЙН ЗАДАРГАА

2017.07.17

Улаанбаатар хот

№	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
Үндэсний Их баяр наадам				
1	Тээврийн зардал /Цэнгэлдэх хүрээлэн, Хүй долоон худаг/	4 удаа	100,000	400,000
2	Гадаад хэлний мэдлэгтэй мэдээллийн ажилтан ажиллуулах, хоол, унааны зардал /Цэнгэлдэх хүрээлэн 2 өдөр, Хүй долоон худаг 3 өдөр тус бүр 2 хүн ажиллах/	4 хүн	150,000	1,500,000
3	Манаач /мэдээллийн төвүүдийн техник хэрэгсэл, эд хөрөнгийг шөнө манах/	5 шөнө	50,000	250,000
	<b>Нийт</b>			<b>2,150,000</b>
Хүрээ цам-Даншиг наадам				
1	Тээврийн зардал /Хүй долоон худаг/	2 удаа	100,000	200,000
2	Гадаад хэлний мэдлэгтэй мэдээллийн ажилтан ажиллуулах, хоол, унааны зардал /Хүй долоон худаг 2 өдөр, 2 хүн ажиллах/	2 өдөр 2 хүн	150,000	600,000
3	Манаач /мэдээллийн төвүүдийн техник хэрэгсэл, эд хөрөнгийг шөнө манах/	2 шөнө	50,000	100,000
	<b>Нийт</b>			<b>900,000</b>
	<b>Нийт дүн</b>			<b>3,050,000</b>

--ooOoo--

ХЯНАСАН:

АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

Б.БАТБААТАР

ТӨСӨВ ЗОХИОСОН:

МЭДЭЭЛЛИЙН ТӨВИЙН МЕНЕЖЕР

С.БАЯРЖАРГАЛ